



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 615

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтын шаардлага хангахгүй нийт 4,000,000.00 (дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Б.Адилбиш нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132007051

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт



Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар  
худалдах автомашины жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын<br>дугаар, арал            | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Гүйлт, км (мянга) | Балансын үнэ,<br>хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг) | Худалдах доод<br>үнэ (төгрөг)                      |
|-----|---------------------------------------------------|-----------------------------------------|-------------------|----------------------------------------------------|----------------------------------------------------|
| 1   | Тоёота марк-2, 03-00<br>ДГО, арал№GX1106066653    | 2003/<br>2011                           | 1120,0            | 2,000,000.00                                       | 1,000,000.00                                       |
| 2   | Элентра, 22-32 ДГН,<br>арал№KMHDG41CAEU2157<br>52 | 2014/<br>2014                           | 1560,0            | 2,000,000.00                                       | 1,700,000.00                                       |
|     | Нийт дүн                                          |                                         |                   | 4,000,000.00<br>(дөрвөн сая)                       | 2,700,000.00<br>(хоёр сая<br>долоон зуун<br>мянга) |